



## БОДЛОГЫН ТОЙМ: СОНГУУЛИЙН АМЛАЛТАА ТӨСВИЙН ХУВЬД ХАРИУЦЛАГАТАЙ ЗАМААР БИЕЛҮҮЛЭХ НЬ 2004 оны 9 дүгээр сар

### Үндэслэл

Ерөнхий Сайдын хэлсэнчлэн, өнгөрсөн сонгуулийн үеэр ард түмэн өөрсдийн дуу хоолойгоо өргөсөн нь Монгол улсын түүхэнд анх удаа болж буй үйл явдал юм. Өөрөөр хэлбэл, дээд удирдлага нь Монголын ард түмнийг нэгтгэх бус харин ард түмэн өөрсдөө удирдлагаа нэгтгэсэн үйл явдал боллоо. Энэ сонгуульд аливаа нэгэн нам илэрхий ялалт байгуулаагүй учраас эвслийн засгийн газрыг хэлэлцээрийн үндсэн дээр байгуулж буй нь Монгол улсын хувьд цоо шинэ үйл явц юм.

Энэхүү хэлэлцээрийг ямар нэгэн эмх замбараагүй байдал гаргалгүйгээр тайван замаар хийж байгаа нь ардчиллын хувьд тус улсын олсон тэмдэглүүштэй амжилт юм. Үүнээс гадна, Монгол орон улс төрийн тогтвортой байдал, ардчиллын түвшингээрээ олон улсын тавцанд дээгүүрт үнэлэгддэг.

Зөвхөн Монголчууд төдийгүй дэлхий нийтээрээ шинээр байгуулагдсан эвслийн засгийн газрын үйл явцыг ажиглах болно. Энэ нь дотоодын санал үл нийлэх явдал үргэлжилсээр байх уу аль эсвэл улс төрийн аль ч нам дангаараа хийж чадахгүй тийм шинэчлэлийг хийхэд зөвшилцөлд хүрэх үү гэдэгт асуудлын гол нь оршиж байна. Ажлын байр нэмэгдүүлэх, Монголын бүх ард түмний амьдрах нөхцлийг сайжруулахад чиглэгдсэн эдийн засгийн бодлогын шинэчлэлийн хөтөлбөр дээр улс төрийн хувьд зөвшилцөлд хүрэх, хэрэгжүүлэх нь эвслийн амжилтыг хэмжих нэгэн шалгуур болох болно.

Хэдийгээр улс төрийн тогтвортой байдал, ардчиллынхаа түвшингээр Монгол улс олон улсын хэмжээнд ихээхэн үнэлэгддэг ч эдийн засгийн асуудлыг нь “Ахилын өсгийтэй” зүйрлэж болно. Өнгөрсөн арван жилийн хугацаанд тус улсын ДНБ нь ойролцоох үзүүлэлттэй орнуудаас доогуур үзүүлэлттэй байж, ашигт малтмал, оёмол сүлжмэл эдлэлээс бусад экспортын бүтээгдэхүүн нь өөрчлөлтгүй юмуу багассан, төсвийн алдагдал, гадаад өр, ДНБ-д эзлэх урсгал тэнцлийн хэмжээ, гадаад актив (импортын, сараар) зэрэг бусад үзүүлэлтүүдээс хамааран Монголын улсын эрсдэл нь “маш өндөр” байна.

Эдгээр байдлыг харгалзан үзэж, эвслийг бүрдүүлж буй намуудаас сонгуулийн үеэр өгсөн амлалтыг эвслийн засгийн газар хэрхэн биелүүлэх вэ гэдгийг олон улсын санхүүгийн байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид, үнэлгээ хийдэг байгууллагууд ажиглах болно. Үүнийг санхүүгийн хувьд боломжтой хувилбараар биелүүлэх үү аль эсвэл үр дүн нь цаашид Монгол улсын эдийн засаг, санхүүгийн эрсдлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх үү?

Аль ч улс төрийн нам засгийн эрхэнд гарахаасаа өмнө буюу сонгуулийн өмнө Монголчуудад өгсөн амлалтаасаа буцах эрхгүй. Гэвч аль ч нам амлалтаа биелүүлэх тодорхой хөтөлбөрийг одоохондоо ил гаргаж тавиагүй учраас хамтран ажиллах тал дээр хэлэлцээр хийх нь чухал юм. Шийдвэрлэх асуудал нь хялбар биш бөгөөд Монгол улсын хувьд дэлхий нийтэд төсвийнхөө боломжийн талаар тодорхой ойлголт өгөхийн зэрэгцээ Монголчуудад өгсөн амлалтаа биелүүлэх хариуцлага хүлээж байгаа учраас эдгээр зорилтуудад хүрэхэд дөхөм болохуйц төсөвт нэг их дарамтгүй, чансаатай арга хэмжээг эрэлхийхэд багагүй цаг хугацаа шаардлагатай.

### Зөвлөмж

Эдгээрээс харгалзан үзвэл зохих нэг арга хэмжээ нь “Эвслийн Зөвлөл”-ийг байгуулан, сонгуулийн амлалтыг биелүүлэх, төсөв, санхүүгийн хувьд боломжтой арга хэмжээнүүд, шаардагдах зардал, зориулалт зэргийг тодорхойлох, хэрэгжүүлэх механизм, үе шатыг төлөвлөх үүргийг хүлээлгэх нь зүйтэй:

- **Эвслийн Зөвлөлийн бүрэлдэхүүн:** Улс төрийн намууд, иргэний нийгмийн өргөн төлөөлөл, хувийн салбар, Монгол улсын олны танил, төвийг сахисан буюу аливаа нэг улс төрийн хүчийг дэмждэггүй экспертүүд
- **Үүрэг:** Хүүхэд, ядууст туслах тал дээр хийсэн сонгуулийн амлалтаа төсвийн хувьд боломжтой аргаар биелүүлэх талаар Монгол улсын Засгийн газарт зөвлөгөө өгөх
- **Олон нийтийн оролцоо, нээлттэй хэлэлцүүлэг:** Иргэдийг хэлэлцүүлэгт татан оролцуулах үүднээс Зөвлөл нь үндэсний хэмжээний нээлттэй хэлэлцүүлгийг зарлан явуулж, шинээр вэб сайт ажиллуулах юмуу эсвэл одоо ажиллаж буй *Нээлттэй Засаг вэб сайтаар* дамжуулан олон нийтийн хэлэлцүүлгээс гарах санал, зөвлөмжүүдийг нийтэд мэдээлэх
- **Мэргэжлийн туслалцаа:** Зөвлөл нь хэнд зориулж ямар хөтөлбөр хэрэгжүүлэх, хөтөлбөр бүрийн санхүүжилтийн тооцоо, хэрэгжүүлэх үе шат, бусад орнуудын туршлага зэрэг асуудалд шаардлагатай мэргэжлийн туслалцааг авах
- **Эцсийн тайлан:** Зөвлөл нь Засгийн газарт зориулан гаргасан зөвлөмж бүхий эцсийн тайлангаа Засгийн газар болон Монголын ард түмэнд Цагаан Сараас өмнө өргөн барина.

Эвслийн засгийн газар нь энэхүү Эвслийн Зөвлөлийг байгуулах тухайгаа “100 хоногийн хөтөлбөр”-ийн нэг хэсэг болгон 10 дугаар сарын эхээр зарлан, Монголчуудад өгсөн амлалтаа биелүүлэх, хүүхэд, ядууст зориулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явцад олон нийтийг татан оролцуулах нь зүйтэй. Ингэх нь Эвслийн засгийн газар төсөв, санхүүгийн хувьд боломжтой, хариуцлагатай аргаар үйл ажиллагаагаа явуулах гэж байна гэсэн “зөв дохиог” дэлхий нийтэд хүргэж чадна.

Олон улсын хандивлагчид эдгээр хүчин чармайлтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн туслалцаа үзүүлэх тал дээр засгийн газартай хамтран ажиллахад бэлэн байгаа гэдэгт ЭЗБШӨЧ Төслийн багийнхан итгэлтэй байна.